

ӨВӨР МОНГОЛЫН ӨӨРТӨӨ ЗАСАХ ОРНЫ ТУХАЙ ТОВЧХОН

Л.БЭГЗЖАВ*

Өвөр Монголын Өөртөө Засах Орон байгуулагдсанахаа 60 жилийн ойг 2007 оны 8-р сарын 1-нд өргөн тэмдэглэв. ӨМӨЗО-ы тухай тус хүрээлэнгээс эрхлэн, “Өвөр Монголын Өөртөө Засах Орон” Улаанбаатар, Москва.1981, номыг монгол, орос хэлээр, М.Зэнээ “Өвөр Монгол, өчигдөр өнөөдөр” УБ.1989. “БНХАУ-ын ӨМӨЗО” УБ.1998 хамтын бүтээл, Ч.Батцэцэг “Монгол Улстай хил залгаа бүс нутаг” УБ. 2007 зэрэг эрдэм шинжилгээний олон ном зохиол хэвлүүлж уншигчдын хүртээл болгосон билээ. Хэдий тийм боловч уншигчдынхаа хүсэлтээр өөртөө засах орны засаг захиргаа, байгалийн баялаг, эдийн засгийн зарим тоо баримтыг товч танилцуулъя.

1947 оны 4-р сарын 23-наас 5-р сарын 3-нд Өвөр Монголын ардын төлөөлөгчдийн хурал Вангийн сүмд (Одоогийн Хянган аймгийн Улаан хотод буюу Манж Чин улсын Энх-Амгалангийн 30-р онд (1691) Хорчин баруун гарын өмнөд хошууны жүн ван Очир энэ газар сүм байгуулж, Вангийн сүм, хятадаар Wang ye miao гэж нэрийджээ) хуралдаж, 5-р сарын 1-ний өдрийг Өвөр Монголын Өөртөө Засах Орон байгуулагдсан өдөр хэмээн зарлаж, Хөлөнбуйр, Навэн мөрөн, Хянган, Шилийн гол, Цахар гэсэн 5 аймаг, 32 хошуу, 1 сян (хошуу, сян хоёр нь засаг захиргааны адил нэгж боловч мал аж ахуйн нутгийг хошуу, тариалангийн газрыг сян гэж ялгана), сяний хэмжээний 3 хоттой байхаар тогтоож, ӨЗО-ы Засгийн газар Вангийн сүмд байрлах болжээ.

1949 онд Хятадад хувьсгал ялсны дараа, мөн оны 11-р сард Хятадын Төв засгийн газрын шийдвэрээр ӨМӨЗО-ы засгийн газрыг Жанчхүүд (Zhang jia kou) нүүлгэн шилжүүлж, 12-р сард ӨЗО-ы засгийн газрыг

ӨЗО-ы Ардын Засгийн газар болгон өөрчлөн зохион байгуулсан байна.

Үүний зэрэгцээ 1949 оны 9-р сарын 19-нд Гоминданы цэргийн эрхтэн, Суйюань мужийн Дун Чиү тэргүүтэй 19 хүн зэвсэгт бослого гаргаж, Суйюаний Ардын Засгийн газар байгуулжээ. 1954 оны 3-р сарын 5-нд, Өвөр Монголын Ардын Засгийн газар, Суйюаний Ардын Засгийн газар, Суйюаний цэргийн хороо, Суйюаний ардын төлөөлөгчдийн хурлын зөвлөлдөх хороо хамтран Гуйюань хотод (Хөх хот) өргөтгөсөн хурал хуралдуулж, Хятадын Төв Засгийн газрын шийдвэрээр 3-р сарын 6-аас эхэлж, Суйюань мужийг байгуулж, Мужийн Ардын Засгийн газрыг татан буулгаж, хуучин Суйюань мужид харъяалагддаг районыг ӨМӨЗО-д нэгтгэж, ӨМӨЗО-ы Ардын Засгийн газрыг Хөх хотноо байгуулжээ. 1955 оны 7-р сарын 30-ны өдөр Жэхэ (уул нь геһе-рэхэ буюу Халуун гол) мужийн Аохань оннигууд, Хорчин хошуу, Чифэн (Улаанхад) Нинчэн, Удан сянийг хамруулан Зуу-Уд аймгийг, 1956 оны 4-р сарын 3-ны өдөр Ганьсу мужийн Баян хотын Өөртөө засах тойрог ба Эзэнэ-гийн Монгол үндэстний Өөртөө засах тойргийг Өвөр Монголд оруулж, Баяннуур аймаг байгуулав.

1969 оны 7-р сарын 5-ны өдөр, Хөлөнбуйр аймаг, Жирэм аймаг, Зуу-Уд аймгийг тус тус Хэйлунзян (Хар мөрөн), Жилинь, Ляонин гурван мужид хамааруулж, Алашаа (хөлөг морь гэдэг утгатай түрэг үг) зүүн гарын хошуу, Алашаа баруун гарын хошуу, Эзэнэ хошууг тус тус Нинся, Ганьсуд харъяалуулж байснаа 1979 оны 5-р сарын 30-нд дахин ӨМӨЗО-д харъяалуулсан байна.

2007 оны байдлаар Өөртөө засах орон нь Хөх хот, Бугат, Ухай, Чифэн, Тунляо,

* Л.Бэгзжав. ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн Хятад судлалын секторын эрхлэгч, доктор (Ph.D), профессор

Ордос, Хөлөнбуйр, Улаанцав, Баяннуур гэсэн 9 хот, Хянган, Алашаа, Шилийн гол гэсэн 3 аймаг, сянийн зэрэглэлийн 11 хот, 17 сянь, 49 хошуу, Орчоон, Эвенк, Морин даваа дагуур гэсэн цөөнх үндэстний өөртөө засах 3 хошуу, хотын харъяа 20 дүүрэг, уурхайн нэг дүүрэгтэй, 1 сая 183 мянган км² газар нутагтай, 23,9 сая хүн амтай, монгол, хань, хотон, манж, солонгос, дагуур, эвенк, орчоон, жуан, сибо, орос зэрэг 55 үндэстэнтэй.

ӨМӨЗО-нь физик газар зүйн хувьд олон янз. Зүүн өмнөдөөс бусад ихэнхи газар нь үндсэндээ өндөрлөг, нийт нутаг дэвсгэрийн 50% орчим нь Хөлөнбуйр, Шилийн гол, Баяннуур, Алашаа, Ордос зэрэг өндөрлөг тэгш тал бөгөөд далайн түвшнээс дээш 1000 орчим м өргөгдсөн, хамгийн өндөр цэг нь Хэлань уулын оргил 3556 м. Монголын өндөрлөг нь Их Хянган даваа Инь уул (Иншань) Чоно уул, Сэртэн уул, (Далан хар, Хүйтний даваа), Хэлань зэрэг уулсаас тогтоно. Өндөрлөгийн баруугаар Бутанчилин, Тэнгэр, Улаанбөх, Хөвч, Муу-Ус зэрэг 150 мянган км² талбай бүхий говь цөл бий. Их Хянган зүүн бэл, Инь уулын хормой, Хатан голын эсрэг Нун мөрний баруун эргийн тэгш тал, баруун Ляо голын тэгш тал, Түмэдийн тал, Бор тохойн тал, Хатан голын өмнөх тал зэрэг нь үржил шимтэй, нарны тусгал сайн, усны эх баялагтай Өвөр Монголын тариалангийн гол нутаг болдог.

Өвөр Монголын нийт нутгийн 53,4% өндөрлөг, 20,9% уулархаг, 16,4% довтолгод, 0,8% гол, нуур, усан сангийн талбай болно.

Байгалийн баялаг арвин, Хятадын бэлчээрийн 21,7%-ийг Өвөр Монгол эзэлнэ. Хөлөнбуйр, Шилийн гол, Хорчин, Улаанцав, Ордос, Урадын зэрэг тал нутагт 1000 гаруй төрлийн тэжээлийн ургамал ургадаг ба нэрд гарсан Саньхэ үхэр, адуу, тал нутгийн улаан үхэр, Үзэмчний том сүүлт хонь, Ордосын нарийн ноолуурт ямаа зэрэг шилмэл омгийн мал сүргээрээ нэртэй.

Өвөр Монголын газрын хэвлийн баялаг асар их, одоогоор 120 гаруй төрлийн ашигт малтмал илрүүлээд байгаагаас 78-ынх нь нөөцийг тогтоожээ. Түүнээс 42 нэрийн ашигт малтмал Хятадаа эхний 10-рт, 22 нь эхний 3-рт, 7 төрөл нь эхний байрт байдаг. Ялангуяа нүүрсний илрүүлсэн нөөц нь 240

тэрбум тонн, бүх Хятадын илрүүлсэн нөөцийн 25%-иас дээш байгаа нь Хятадад 2-р байранд ордог. Нийтдээ 1200 тэрбум тонн нөөцтэй гэж үнэлэгддэг нь Синьзяний дараа ордог. Газрын тос, байгалийн хийн асар их нөөцтэй, олж тогтоогоод байгаа нефтийн 13 том талбайн газрын тосны хэмжээ урьдчилсан тооцоогоор 2-3 тэрбум тонн ажээ.

Төмөр, марганец, хром зэрэг хар төмөрлөгийн орд арвин, төмөрлөгийн 63 уурхай, түүнээс том, дунд хэмжээний 15 орд газрын нөөц нь Хятадад 9-р байранд, өнгөт төмөрлөгийн илрүүлээд буй нөөц, цайр, хөнгөн цагаан, висмутын нөөцөөр 5-р байр, зэс, гянтболд, молибден, никель зэрэг нь 7-10-р байранд байна. Ялангуяа Хятадын ховор шорооны нөөцийн 90% нь Өвөр Монголд байдаг нь дэлхийд Бразилийн удаад ордог. Бериллий, тантал, кобальтийн нөөцөөр дэлхийд 1,2-р байранд явдаг.

ӨМӨЗО нь Хятадын ой модны нэн чухал газрын нэг, 18,6 сая га ойн талбайтай нь Хятадын ой модны 11%-ийг эзэлж, улсдаа тэргүүлдэг. Ойн нөөц 1,1 тэрбум куб м бөгөөд Хятадаа 4-рт орно. 2167 төрлийн хээрийн ургамал, 24 зүйлийн 114 төрлийн ан амьтан, 51 зүйлийн 365 төрлийн жигүүртэн шувуутай.

Тал нутаг, түүх дурсгал, элсэн говь, нуур далай, ой шугуй, ёс заншлын “6 том гайхамшиг”-аараа Өвөр Монголын аялал жуулчлалын биеэ даасан өнгө төрхийг илтгэдэг. Өвөр Монголд очсон хэн боловч Хөх хотын Таван суваргат сүм, Ширээт зуу, Их зуу хийд, Жаожүний бунхан, Уст зуу, Цагаан суварга, Бугат хотын Бадгарын хийд, Эзэнэ хошууны Чингисийн онгон гэх мэт түүх дурсгалын олон газрыг сонирхон үздэг.

Энэхүү өргөн уудам газар нутаг, байгалийн асар их баялагтаа тулгуурлан, Өвөр Монголын ард түмний шинэ цагийн бүтээн байгуулалт асар хурдацтайгаар өрнөж, эдийн засгийн эрч хүч өдрөөс өдөрт нэмэгдэж байна.

2006 онд ӨЗО-ы дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ 60.4 тэрбум ам.долларт хүрч 2005 оныхоос 23%-иар нэмэгдэж, нэг хүнд ноогдох нь 2.5 мянган долларт хүрч, өнгөрсөн оныхоос 22.8%-иар өсөв. Улс ардын аж ахуйн үлэмж хөгжиж буй салбар гэвэл уул уурхай, төмөрлөг, хөдөө

аж ахуй (чихрийн манжин, хонины мах, сүү цагаан идээ), хөнгөн аж үйлдвэр (ноолууран бүтээгдэхүүн) болно. Газар тариалан, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний дахин боловсруулалт, эрчим хүч, төмөрлөг, цахилгаан тоног төхөөрөмж, машин үйлдвэрлэлийн хэмжээ нэлээд их өсөж байна. Тухайлбал чихрийн манжин, буурцагт ургамал, жимс, сүү, махны үйлдвэрлэл 2005 оныхоос 2006 онд 50% нэмэгдсэн статистик үзүүлэлт гарчээ.

Тус ӨЗО-ы хэрэглээний барааны жижиглэн худалдаалах хэмжээ 2006 онд 20.4 тэрбум доллар буюу 2005 оныхоос 18% өссөний дотор хотод 14 тэрбум (20%) доллараар өсчээ. 2006 онд автомашин, орон сууц зэрэг том хэмжээний барааны гүйлгээ 25% өсөж, холбоо мэдээллийн хэрэгсэл бараг 4 дахин нэмэгдсэн байна.

Өвөр Монголын гадаад худалдааны эргэлт 2006 онд 6.7 тэрбум ам.доллар (+30%) түүний дотор экспорт 2.6 тэрбум ам.долларт (+25%) хүрчээ. ОХУ, Монгол Улстай 4200 гаруй км хилийн шугамтай Өвөр Монгол нь Хятадын “Умар зүгийн нээлттэй хаалга” болж байна. Одоо ӨЗО-ы импорт экспортын эрх бүхий 3173 аж ахуйн нэгж байна. 2006 онд Оростой хийсэн Өвөр Монголын худалдааны эргэлт 2.29 тэрбум ам.доллар буюу 30.5%-иар өссөн бол Монгол Улстай хийсэн худалдааны эргэлт 580 сая ам.доллар буюу 57.9%-иар өсчээ. Өвөр Монголын гадаад эдийн засгийн худалдааны 10 том түншийн дотор Монгол Улс нь ОХУ-ын дараа явж байна.

ӨМӨЗО-ы 2006 оны улс ардын аж ахуй, нийгмийн хөгжлийн тоо баримтыг хүснэгтээр үзүүлье.

Аж үйлдвэр

	2006 он	2005 онтой харьцуулбал
Нүүрс олборлолт	297 сая. тн	16.2
Түүхий нефть гаргалт	1,7 сая. тн	17.0
Бензин	605 мян. тн	34.6
Дизель	530 мян. тн	31.6
Бордоо	766 мян. тн	16.8
Өнгөт металл	916 мян. тн	30.0
Цемент	21,1 сая. тн	35.5
Байгалийн хий	5.307 тэрбум м ³	37.6
Гар утас үйлдвэрлэл	2, сая ширхэг	106.1
Өнгөт телевизор	3,3 сая. ширхэг	39.6

Хөдөө аж ахуй

	2006 он	2005 онтой харьцуулбал
Үр тариа	17 сая тн	2.6
Жимс	2,2 тн	23.3
Хүнсний ногоо	11,7 сая тн	16.4
Мах үйлдвэрлэл	2,5 сая тн	11.8
Гахайн мах	948 мян	7.8
Үхрийн мах	381 мян	13.6
Хонины мах	847 мян тн	17.0
Ноолуур	6792 тн	2.2
Хонины ноос	98 мян тн	2.5
Бод малын тоо	10 сая	7.8
Бог мал	89 сая	3.3
Гахай	10 сая	8.2

Боловсрол шинжлэх ухаан

Дээд сургууль	36
Тусгай мэргэжлийн дунд сургууль	256
Ахлах шатны дунд сургууль	359
Анхан шатны дунд сургууль	1199
Бага сургууль	4884
Шинжлэх ухаан техникийн том ололт	205
Түүнээс: онолын суурь судалгаа	24
хавсарга судалгаа	179
Патент авсан бүтээл	978
Бүтээгдэхүүний чанарыг шалгах байгууллага	96

Соёл урлаг, эмнэлэг

Урлагийн байгууллага	147
Соёлын ордон	102
Нийтийн номын сан	110
Музей	33
Архив	140
Радио нэвтрүүлгийн станц	13
Ном хэвлэл	63.9
Түүнээс монгол хэлээр	8,1 сая
Эмнэлгийн байгууллага	3693
Үүнээс эмнэлэг	474
Хөдөө орон нутгийн эмнэлэг	1325

Хүн ам

Шинээр төрсөн	235800
Хүн амын өсөлт	9.87%
Нас барсан	141200
нас баралт	5.91%
цэвэр өсөлт	3.96%
Бүх хүн ам	23.923.500
өнгөрсөн оныхоос нэмэгдсэн	59500
монгол үндэстэн	4,2 сая
хотын хүн ам	11,6 сая
эзлэх хувийн жин	48.6%

хөдөөгийн хүн ам	12,3 сая
эзлэх хувийн жин	51.4%
эрэгтэйчүүд	12,3 сая
эмэгтэйчүүд	11,6 сая
65-аас дээш настан	1,6 сая
хотын хүн амын дундаж орлого	10388 юань
үнийн өсөлтийг хасвал	+12%
хөдөөгийн хүн амын дундаж орлого	3342 юань
үнийн өсөлтийг хасвал	+10%

Амьдралын түвшин

Хотын 100 өрх тутамд ногдол	
өнгөт телевизор	113
хөргөгч	87
цахилгаан сэнс	61
угаалгын машин	96
гэрийн компьютер	27
автомашин	4
Хөдөөгийн 100 өрх тутамд	
телевизор	10
түүнээс өнгөт телевизор	90
хөргөгч	20
цахилгаан сэнс	21
угаалгын машин	46.50
мотоцикль	6049

Ашигласан материал:

1. “Nei menggu diming” (Өвөр Монголын газрын нэрс) Хөххот. 2006 оны 6-дугаар сар. /хятад хэлээр/
2. “Zhe jiu shi Nei menggu zi zhi-qu” (Энэ бол Өвөр Монголын Өөртөө Засах Орон) Ерөнхий редактор Улаан. Бээжин. 2007 он 7-р сарын 1 /монгол, хятад, англи, орос хэлээр/
3. “Nei menggu gibao” (Өвөр Монголын өдрийн сонин) 2007.3.6 /хятад хэлээр/
4. <http://ru.wikipedia.org/wiki/>